

Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)



Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/nb7h-8h46-6xea

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVIII • 2025 • № 1

Выходит 4 раза в год

Издается с 1986 г.

Учредитель: ФГБУН

Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор,*
доктор филологических наук (Россия)

Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат*
филологических наук (Россия)

М. А. Козинцев, *помощник секретаря,*
кандидат исторических наук (Россия)

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*

А. Бирталан, *доктор наук (Венгрия)*

Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*

Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*

И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН*
(Россия)

Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*

В. Капишовска, *доктор наук (Чехия)*

Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук*
(Монголия)

С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*

К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*

М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*

Р. Поп, *доктор наук (Румыния)*

Ц. Саранцацрал, *доктор филологических наук*
(Монголия)

Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор*
(Россия)

С. Чулуун, *академик МАН (Монголия)*

Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*

Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*

Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева

Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек

Технический редактор – М. А. Козинцев

Подписано в печать 20.03.2025

Формат 60×90 1/8. Объем 7 печ. л. Заказ №

Тираж 300 экз.

Отпечатано в типографии ООО «Литография Принт».

Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8,
лит. А, офис 14.

e-mail: info@litobook.ru

12+

© Институт восточных рукописей РАН
(Азиатский Музей), 2025

© Коллектив авторов, 2025

В НОМЕРЕ:

М. П. Петрова. К 70-летнему юбилею профессора кафедры Монголоведения и тибетологии Восточного факультета СПбГУ В. Л. Успенского 5

ФИЛОЛОГИЯ

О. К. Бабаева. «Песнь о Буревестнике» А. М. Горького на калмыцком языке..... 8

Б. Дайриймаа. Монгол аж байдлын үлгэр дэх гэр бүлийн харилцааны илрэл..... 13

ИСТОРИЯ. КУЛЬТУРА

Г. Батдорж, Б. Батжаргал. Актуальные проблемы методики военно-музыкальной подготовки в Монголии 18

В. Ю. Жуков. На чьи средства построен буддийский храм «Дацан Гунзэчойнэй» в Санкт-Петербурге (1909–1915 гг.): опыт исторического аудита 29

НАУЧНАЯ ЖИЗНЬ

Ю. В. Болтач, И. В. Кульганек. XIII Санкт-Петербургские тибетологические чтения, посвященные 300-летию Российской Академии наук (Санкт-Петербург, ИВР РАН, 13–14 ноября 2024 г.)..... 37

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)



191181. Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18
Phone: +7 (812) 315-87-28
<http://orientalstudies.ru>
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVIII • 2025 • No. 1

The journal is published four times a year.

Published since 1986

Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*
D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*
M. A. Kozintcev — *assistant secretary Cand. Sci. (History), Russian Federation*
G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*
A. Birtalan. *Ph. D., Hungary*
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*
L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
J. Legrand. *Dr. Sci., Professor, France*
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*
E. E. Khabunova, *Dr. Sci. (Philology), Russian Federation*
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*
E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*
S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*
R. Pop. *Ph. D., Romania*
Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*
T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*
R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*
N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*
I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/nb7h-8h46-6xea

© Institute of Oriental Manuscripts RAS
(Asiatic Museum), 2025
© Group of authors, 2025

IN THIS ISSUE:

M. Petrova. 70th Birthday of Vladimir L. Uspensky, Professor of the Department of Mongolian Studies And Tibetology of The Faculty of Asian and African Studies of St. Petersburg State University 5

PHILOLOGY

O. Bavaeva. “The Song of the Stormy Petrel” by Maxim Gorky Translated into the Kalmyk Language 8

B. Dayriima. Manifestation of Family Relations in Mongolian Non-fairy Tales 13

HISTORY. CULTURE

G. Batdorj, B. Batjargal. Topical Issues of Military Musical Training Methodology in Mongolia 18

V. Zhukov. At Whose Expense was the Buddhist Temple «Datsan Gunzechoinei» in St. Petersburg Built (1909–1915)? An Attempt of Historical Financial Audit 29

ACADEMIC LIFE

I. Boltach, I. Kulganek. The 13th St. Petersburg Seminar of Tibetan Studies Dedicated to the 300th Anniversary of the Russian Academy of Sciences (St. Petersburg, IOM RAS, November 13–14, 2024) 37

Б. Дайриймаа
Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

МОНГОЛ АЖ БАЙДЛЫН ҮЛГЭР ДЭХ ГЭР БҮЛИЙН ХАРИЛЦААНЫ ИЛРЭЛ

Монгол ардын үлгэр төрөл зүйлийн онцлогоосоо үл хамааран нийгмийн янз бүрийн үзэгдлийг шууд буюу ёгт далд утгаар дүрсэлсэн байдаг. Энэ нь гол төлөв адгуус амьтны болон шидэт үлгэрт түлхүү ажиглагдах бөгөөд харин аж байдлын үлгэрт ихэвчлэн шууд утгаар илрэх боловч мөн далд, бэлгэдэлт хэлбэрээр илрэх нь элбэг тохиолдоно. Нийгмийн үзэгдлийн олон хэлбэр үлгэрт тусгалаа олсон байдгаас аж байдлын үлгэр дэх гэр бүлийн харилцааны асуудал нэлээд сонирхолтой юм. Үүнийг хатад хоорондын, мөн ах дүүсийн дундах зөрчил, тэмцлийн жишээгээр харуулахыг зорьжээ.

Түлхүүр үг: Тусгал, хэв шинж, нийгмийн байгуулал, бэлгэдэл, үнэлэмж.

Зохиогчийн мэдээлэл: Баасанжаргал Дайриймаа. Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Аман зохиол судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан (dairiimaab@mas.ac.mn).

© Дайриймаа Б., 2025

Ардын үлгэрийн дотоод төрөл зүйл бүхэн, адгуус амьтны үлгэр, шидэт үлгэр, аж байдлын үлгэрүүд нь ямар нэг хэмжээгээр тухайн үлгэр яригдаж байх үеийнхээ хүний нийгмийн орчин, сэтгэлгээг тусгасан байдаг нь хүн төрөлхтний хамгийн эртний нийгмийн харилцааны үед үүсч бий болсон домогзүйн сэтгэлгээ, улмаар түүнийгээ хийсвэрлэн сэтгэж, илэрхийлэн үлдээж байсан нэн эртний урлагийн төрөл зүйлсээс эхлээд бичиг үсэг үүсэхээс өмнөх үеийн аман уламжлалаас улбаатай юм. Ардын үлгэрийн санд онцгой байр эзэлдэг, уран сэтгэмж, хэтрүүлэлт уран дүрслэлээр хязгаарлагдмал, өгүүлэмжийн үндсэнд нь энгийн аж төрөл, ахуй, түүнээс үүдсэн зөрчил тусгагдсан, сэдэв агуулгын хувьд өргөн баялаг хэсэг бүлэг үлгэрийг аман зохиол судлалд аж байдлын үлгэр хэмээн ялган нэрлэж, судалсаар иржээ. Аж байдлын үлгэр зарим нэг эртний зан заншил, ахуй соёлын чанартай өгүүлэмжээс гадна шог хошин шинж тэмдгээрээ нийгмийн шүүмжлэлт утга санааг агуулж байдаг тул тодорхой хэмжээгээр түүхэн мэдээллийг дамжуулж байдаг байна. Энэ хэв шинжийн үлгэрийн үүсэл гарлыг судлаачид овгийн байгуулал задарч гэр бүл үүссэн, улмаар хувийн өмч үүссэн үе, боолын нийгмийн үүсэл, аж

амьдралтай холбон тайлбарлах нь буй. Өөрөөр хэлбэл, нийгмийн тэгш бус байдал үлгэрт тусгалаа олж, улмаар шүүмжлэлт шог хошин өнгө аястай аж байдлын үлгэрийн өгүүлэмж, мотивын үүсэх нэгэн хөшүүрэг болсон ажээ. Ийм учраас ардын үлгэр бол нэгэнт хүний оюун бодолд үүсэн ургаж, уламжлагдан яригдаж байдгийн хувьд нийгмийн аливаа феномен, үзэгдлээс ангид байх боломжгүй бөгөөд зөвхөн хийсвэрлэн зохиомжилсон уран сэтгэмжийн аргаар бүтэж, агуулгаараа хүн төрөлхтний мөрөөдөл хүслийн илэрхийлэл болон оршоор иржээ.

Шидэт үлгэр болон аж байдлын үлгэрийн зөрчлийн шалтгаан, эх үүсвэр нь ихэнх тохиолдолд адил төстэй байдаг. Тухайлбал, шидэт үлгэрийн үйл явдлын зөрчил нь зарим талаар гэр бүл, ахуйн шалтгаанаас үүдэлтэй (үүнд: ах дүү нарын, хойд эхийн, хатадын зөрчил мотив) байдгаараа ердийн аж байдлын үлгэртэй адил төстэй буюу нийтлэг шинжтэй байна. Гэвч шидэт үлгэрийн үйл явдал өрнөх хөрс нь шидэт, ер бусын уран сэтгэмжийн ертөнц байж, шидэт туслагч нарын хүчээр ялалт байгуулдаг бол аж байдлын үлгэрийн үйл явдал бодит орчинд өрнөж, өөрийн оюун ухаан, хүч чадлаараа зорьсондоо хүрч байдаг онцлогтой. Бодит бай-

длын дүрслэл, уран сэтгэмжит мотивтой сүлэлдсэн нь үлгэрийн тогтвортой бүтэц, зохиомжид нөлөөлөх зүйлгүй юм. Монгол ардын аж байдлын үлгэрт гэр бүлийн харилцааны болоод, нийгэм ахуйн шүүмжлэлт сэтгэлгээ бүхий үлгэрүүд томоохон байр эзэлдэг. Түүний үйл явдал, агуулга, үзэл санаа, өгүүлэмжийн цөм нь цэцэн мэргэн хүмүүс (бүсгүй), тааварч мэргэн хүүхдүүдийн тухай, овжин сэргэлэн хулгайчдын сэдэв байх бөгөөд, хэмжээний хувьд арай том туурилаг, шидэт үлгэрийн элементүүд сүлэлдсэн холимог хэв шинжтэй үлгэрүүд ч цөөнгүй тохиолдоно. Нэлээд хожуу феодалын нийгмийн үеийн ардын үлгэрийн хувьсал, хөгжлийн нэг жишээ нь тухайн үеийн нийгмийн нөхцөл байдал, зан төлөвийг илүү их шингээсэн шүүмжлэлт, шог хошин үлгэрүүд юм. Эдгээрт бадарчны үлгэр, түүний хэв шинж бүхий хурц, шүүмжлэлт үлгэрүүдийг багтаан үздэг бөгөөд нэрт эрдэмтэн, судлаач Ш. Гаадамбын бичсэнчлэн “аж байдлын үлгэр гол төлөв хүний ёс суртахуун, гоо зүй, анги нийгмийн хэв төлөвийн хүмүүсийн хоорондын харилцаа холбоо, тэгш эрх, эрх чөлөө зэрэг ард түмний аж төрлийн цаг үеийн чухал асуудал бүхэнд зориулагдсан байна” [Гаадамба, 1987. Х. 143].

Монгол ардын үлгэрийн эхүүдийг эртний домогзүй, итгэл үнэмшил, тотем шүтлэг, соёл, гүн ухаан зэрэг олон талаас нь авч үзсэн байдаг ба нийгмийн нөхцөл байдлыг харгалзан гэр бүл, түүний гишүүдийн харилцааг дүр, өгүүлэмжийн харилцан хамаарлын хүрээнд дүн шинжилгээ хийж, олон янзын гаргалгаа гаргасан нь аман зохиол судлалд цөөнгүй юм. Монгол аж байдлын үлгэрт гэр бүлийн загвар, модель нь тухайн эхийн өгүүлэмж, үйл явдалтай нягт холбоотойгоор ихэвчлэн үлгэрийн эхэнд тодорхой илэрдэг. Үлгэр гол төлөв тэнэг хүүтэй нэгэн хаан, хааны хүү, ядуугийн хүү хоёрын тухай, ганц хүүтэй ядуу эмгэн өвгөн хоёр, эсвэл өнчин, тааварчин ах дүү нарын тухай гэх мэтээр гол баатрынхаа гэр бүлийн байдал буюу нийгмийн гарал байдлаас эхлэх бөгөөд гэр бүлийн дүр зураг ихэвчлэн хийсвэр, бэлгэдлийн чанартай дүрслэгдэнэ. Ялангуяа аж байдлын үлгэрт гол баатар маш биеэ даасан шинжтэй, өөрөө асуудлыг шийддэг, хөндлөнгийн туслалцаа авах тохиолдол бараг гардаггүй.

Монгол аж байдлын үлгэр дэх гэр бүлийн харилцааны тусгалын нэгэн жишээ нь хаан болон хатадын зөрчлөөр илэрдэг. Хаан бол шидэт болон аж байдлын үлгэрийн уламжлалт дүр юм. Ихэнх үлгэрт хаан өөрийнхөө ухаанаар бус хорон санаат түшмэл буюу хатныхаа үг, хатгаасаар гол баатарт саад бэрхшээл, элдэв аюул тогтор учруулдаг бол, зарим үлгэрт хаан гол баатарт хор хүргэхгүй, дэд буюу хоёрдугаар шатны идэвхгүй дүр байх бөгөөд үлгэрийн эхэнд дөнгөж дурдагдан өнгөрдөг. Тухайлбал, “Хааны эзгүйд” [Гаадамба, Цэрэнсондном, 1978. Х. 179] хэмээх үлгэрт гурван хатантай хааны тухай гарах бөгөөд алс хол явахаар болсоноо хатаддаа хэлж, буцаад ирэхэд нь өөрт нь зориулж юу бэлдсэн байх тухай асууж хэлүүлээд явдаг. Харин их, дунд хоёр хатан нь нийлж хамгийн бага хатныг гүжирдэн хорлож, энэ нь сүүлд илэрч хоёр хатнаа хөөж явуулснаар үлгэр төгсдөг. Энэ үлгэрт гэр бүлийн зөрчил нь их хатдын явуулга, тэмцлээр илэрч байх бөгөөд үлгэр дэх гэрлэлтийн харилцааны эртний хэлбэр, хэв шинжийн нэг тусгал юм. Нэрт эрдэмтэн, судлаач Ш. Гаадамба ийм олон хатант хааны өгүүлэмж бүхий үлгэрийг анги нийгмийн нөхцөл байдлын үүднээс авч үзээд “Ийм үлгэр олонхдоо нэг хүний олон гэргийн хүүхдээс хэн нь хан эцгийн сууртнд суух вэ гэсэн ширээний төлөө тэмцлийн тусгал мөн гэмээр байдаг. Үүнд полигами буюу олон эхнэр авах ёс байсан дээрээс “эх нар” гэдэг үг “гэргий” гэсэн утгатай болсон үг хэлний баримт ч үүнийг харуулна” [Гаадамба, Сампилдэндэв, 1988. Х. 274] хэмээн хэлний үзэгдэлтэй холбон сонирхолтой ажиглалт хийжээ. Хатдын зөрчилдөөн бүхий “Ерэндэй мэргэн хаан” [Цэрэнсондном, 2009. Х. 232] үлгэрт бага хатан алтан цээжтэй, мөнгөн бөгстэй хүү төрүүлэхэд хоёр хатан ам хамрыг алчуураар боож, үүд босгын доор нүх малтаж булж тавиад хүүхдийнх нь оронд нэг нохойн гөлөг авчраад хааны ордон даяар — Хааны бага хатнаас нэг нохойн гөлөг гарлаа хэмээн цуурхал тараадаг. Хаан ирээд бага хатнаа аргалч болгоно. Улмаар хаан учрыг мэдээд хоёр их хатны ард нь араг хадаж, гарт нь савар атгуулж насан туршид боол болгон шийтгэж бага хатнаа авчирч буйгаар үлгэр төгсөнө. Энэ хоёр үлгэр нэг нь ид шидийн, баатарлаг хэлбэртэй шидэт үлгэр,

нөгөө нь аж байдлын хөрсөн дээр үйл явдал өрнөх, элдэв хэтрүүлэлт уран сэтгэмжгүй агуулга, өгүүлэмжийн хувьд хоёр өөр хэв шинжийн үлгэрт хамаарч байна. Тийм боловч гурван хатнаа орхиж явахдаа хааны асуусан асуулт, явсных нь дараах хатдын үйлдэл, хааны шийтгэл, бага хатны цагаатгал зэрэг мотивын хувьд ижил байгааг аж байдлын үлгэрийн хувьсал хөгжлийн нэгэн жишээ гэж үзэж болно.

Аман зохиолын онолын судлалын дэг сургуулийг үндэслэгч, харьцуулсан аман зохиол судлаач Оросын эрдэмтэн Е. М. Мелетинский ардын үлгэрийн нийгэм, түүхийн үндсэнд харьцуулсан дүн шинжилгээ хийсэн бүтээлдээ ямар ч гэм буруугүй мөртөө хавчигдан хэлмэгдсэн бүсгүйн дүрийн тухай “Хэлмэгдсэн бүсгүйн тухай бүхий л үлгэрүүд бол ямар нэгэн хэмжээгээр нийгмийн утга учир агуулж байх бөгөөд түүхэн тодорхой үйл явцын тусгал байдаг. Нөхөртөө хаягдаж орхигдсон бүсгүйн дүр байнга тохиолдох нь цэвэр сэтгэлзүй-ахуйн шинжтэй юм” [Мелетинский, 2005. С. 39] хэмээгээд зөвхөн эцгийн эрхэт ёс үүсэн хөгжсөнөөр ийм хэлмэгдсэн бүсгүйн тавилан эмгэнэлтэй болсон ба нөхөр нь эхнэрийнхээ овогт шилжин ирдэг байсан эхийн эрхэт ёсны үед харин ямар ч аюул заналхийлэлд өртөлгүй овогтоо буцан ирдэг байжээ гэжээ.

Олон хатантай хааны тухай үлгэр аж байдлын үлгэртэй харьцуулбал шидэт үлгэрт нэлээд тохиолддог. Тухайлбал, “Буянт хүү, Ерөөлт хүү” хэмээх шидэт үлгэрт хааны их хатан өөрийн хүүг хаан ширээ залгамжлуулахаар бага хатны хүүг элдвээр хорлож алс газар явуулж байгаа тухай гарна. Энэ үлгэрийн үндсэн агуулга, үйл явдал нь хатдын хоорондын өрсөлдөөн гэхээс илүү өөрийн хүүхдээ хаан болгох гэсэн их хатны хорт явуулга голлон дүрслэгдэх учраас цаашдын өрнөлт, үйл явдалд бага хатны дүр бараг гардаггүй. Үүнээс бид нэг талаар өөрийн хүүхдийн нийгмийн байр суурийг илүүд үзэж, янз бүрийн явуулга хийж хаан болгох гэсэн санаа зорилго, тэмцлийн ул мөрийг харж болно. Ер нь ардын үлгэрийн дүрийн онцлогийг гол төлөв нийгэм, түүхийн, сэтгэлгээний онцлог гэх мэт нөхцөл байдалтай уялдуулан авч үзэх нь түгээмэл бөгөөд энэ нь ч аман зохиол судлалын судалгааны гол зарчим байсаар иржээ.

Түүнээс гадна, үлгэрийн хааны дүр бол хүмүүсийн ухамсарт нэгдмэл байдлыг илэрхийлсэн нэн эртний үлгэр, домгийн бэлгэдлийн, ёгтлолт чанар, домогзүйн үндсийг агуулж байгаа дүр гэж үзэж болох юм. Аман зохиолын болон домог зүйн судалгаанд үлгэрийн аливаа дүр, мотивыг домогзүйтэй холбон тайлбарлахын зэрэгцээ нийгмийн байгууллын өөрчлөлтийн тусгал талаас нь авч үзсэн байдаг. Тухайлбал, ардын үлгэр дэх гэр бүл, түүний харилцааны утга зүйг тодруулахдаа нэн эртний домгийн ул мөрөөс эрэл хайгуул хийсэн нэгэн судалгаанд “Үлгэрийн утга зүй бол зөвхөн түүний домог зүйн эх сурвалжуудаар тайлбарлагдана. Тэгэхдээ, домгийн утга зүйгээс ялгаатай нь үлгэрт нийгмийн код илүү давамгайл байна. Домог зүйн амьдрал ба үхэл гэх мэт үндсэн эсрэгцэл нь үлгэрт гэр бүлийн дотоод харилцааны хэлбэрээр илрэх нийгмийн зөрчил, сонирхолд байр сууриа тавьж өгчээ. Нэн эртний үлгэрт гэр бүлийн сэдэв зөвхөн хөндөгдөх бөгөөд түүнээс “том гэр бүл”-ийн бэлгэдлийн шинж тэмдгийг харж болно. Өөрөөр хэлбэл, дагавар охины ч юмуу, эсвэл адлагдсан бага дүүгийн өгүүлэмж нь овгийн байгууллын задралыг илтгэх нийгмийн утга санааг агуулсан байдаг” [Мордовина, Пеньков, 2009. С. 88–89] хэмээн тэмдэглэжээ.

Монгол ардын шидэт болон аж байдлын үлгэрийн гэр бүлийн ерөнхий дүр зургийг мөн өвгөн эмгэн хоёр, тэдний хүү, ах дүү нарын зөрчил, эсвэл гүтгэгдэн хэлмэгдсэн бэр зэрэг өгүүлэмж бүхий үлгэрүүдээс харж болох юм. Гэвч, гэр бүлийн харилцааны илрэл зарим үлгэрт маш хийсвэр бөгөөд үлгэрийн гол зөрчил, өгүүлэмжийн шугам зөвхөн гол баатрын үйл явдал, дүрслэл дээр төвлөрсөн байх нь олонтоо. Тухайлбал, “Сүүлэнхүү” үлгэрт өвгөн эмгэн хоёр ямааны сүүлнээс бий болсон хүүтэй болж баярлалдан хамт амьдарч байтал хүү нь овоо өсч үдэш орой малаа хотлуулах болжээ. Ингээд нэг удаа хоёр хулгайчтай таарснаар хааныхаас хулгай хийх адал явдал нь эхэлдэг. Энэ үлгэрийн эхэнд хүү ямааны сүүлнээс бий болж байгаа нь эртний ойлголтын нэгэн илрэл бөгөөд дэлхийн бусад ард түмний үлгэрт ч түгээмэл тохиолддог “гайхамшигт төрөлт”-ийн мотив юм. “Сүүлэнхүү” үлгэрийн нийгмийн

агуулга, утга санааг хаан, хатан хоёрыг төдийгүй хамтарч хулгай хийсэн шунахай хоёр хүнээ чадаж байгаагаар нь тайлбарлаж болох юм. Монгол ардын үлгэрийн ялгарах нэгэн онцлог бол баатрууд нь ноорхой хүү, хэрсүү ухаалаг хүү, цэцэн цэлмэг хүү, тааварчин хөвгүүд, сэргэлэн зальжин, дүрсгүй сахилгагүй хүү, хэгжүүн хэлэмгий хүү, хэнд ч гэмгүй дорой буурай, бас тэнэгдүү хэрнээ аз үргэлж ивээж байдаг хүү гэх мэт жендерийн хувьд эрэгтэй хүүхдийн дүр давамгайлах байр суурьтай байдаг. Эдгээр хүүхдүүд ихэвчлэн өнчин, ядуу, ах дүүс, эсвэл ядуу өвгөн, эмгэний хүүхдүүд байна. Монгол ардын үлгэрийн хүүгийн дүрийг судлаачид нэлээд эрт овгийн байгууллын явцад үүсч бий болж байсан гэр бүл, нийгмийн янз бүрийн үзэгдлүүдтэй холбон тайлбарласан байдаг.

Түүнчлэн, ах дүү нарын хоорондын зөрчлийг тусгасан монгол үлгэрээс гэр бүлийн орчны, харилцааны ерөнхий дүр зургийг олж харж болно. “Ах дүү гурав” үлгэрт хоёр ах нь дүүгээ аргал, хоргол түүгээд ирэх хооронд зургаан хүзүүний тавыг нь идээд нэгийг нь үлдээсэн байна. Ингэснээр дүү нь гурван тийш салж явах санал гаргаж, өөрөө нэгэн улсын өгөөмөр баян хаан болоод, харин хоёр ах нь нэг нь үхэж, нөгөө нь ядарч явсаар дүүгээ олж байгаа өгүүлэмжтэй юм. Энэ үлгэр монгол үлгэрийн туурвилын түгээмэл арга болох “гурав”-ын загварын тод жишээг харуулдаг. Тухайлбал, ах дүү гурав, гурван мод, гурван тийш салж одох гэх мэт. Академич Х. Сампилдэндэв хүзүүний ясаар бат бэхийн холбоог бэлгэддэг монголчуудын эртний заншлын ул мөр энэхүү үлгэрт туссаныг дурдаад “Ах дүү гурав” үлгэрт гурван үе хүзүү идсэн ахмад нь хувхайрсан мод шиг үхээд, хоёр

хүзүү идсэн дундах нь гандсан мод шиг гуйлгагч болж ганц хүзүү идсэн дүү нь багсайн сагсайн ургасан мод шиг нэг улсын хаан болжээ. Ийнхүү шударга бишээр хохирсон нь сайн хувь заяа, хуурч завшсан нь муу хувь тавиланд учирснаар үзүүлсэнд ард түмний үнэн ёс суртахуун, хохирогсдын талыг барьсан үзэл илэрчээ” [Гаадамба, Сампилдэндэв, 1988. Х. 282] хэмээн онцолсон байдаг. Ах дүү нарын харилцааны үлгэрээс бид нэг талаас, ёс суртахууны үнэт зүйлсийг агуулсан элементүүдийг, нөгөө талаас түүний агуулга, илэрхийлэлд орших ард түмний үнэлэмж, шүүмжлэлт сэтгэлгээний учир холбогдол, харьцааг харж болох юм.

Энэ мэтчилэн, монгол ардын үлгэрийн гүн гүнзгий утга агуулга бүхий өгүүлэмжийн үндсэнд гэр бүлийн байдал, харилцаа, цаашилбал заншил ёс, уламжлалын элементүүд нягт харилцаа холбоотой оршихоос гадна монголчуудын нийгмийн байгууллын түүхэн хувьсал хөгжил, аж амьдралын өвөрмөц онцлог нь ардын үлгэрийнхээ сэдэв агуулга, үзэл санаа, дүрийн тогтолцооны түвшинд нөлөөлсөөр ирснийг олон жишээгээр тодруулж болно. Ер нь ардын үлгэр үүсч бий болсон үеэсээ л хүний амьдралд байж болох бүхий л үйл явдал, нөхцөл байдлын талаарх буй ямар нэгэн мэдээллийг дамжуулж, мөн нууцлаг далд утга агуулж байдгаараа бэлгэдлийн шинжтэй байдаг ажээ. Тэрчлэн, нийгэм, улс төр, угсаатны зүй, соёл, гүн ухаан, сэтгэл судлал зэрэг олон шинжлэх ухааны судлагдахууны заагт оршихын хувьд түүнээс ард түмний тухайн үлгэр яригдаж байсан цаг үеийн нийгмийн байдал, түүнийг дагасан сэтгэл зүйн зарим шинжүүдийг ч илрүүлж болох өргөн судлагдахуун ажээ.

Ном зүй

Гаадамба, 1987: *Гаадамба Ш.* Монгол ардын үлгэр // *Studia Folclorica*. Т. XIV. F. 1. ШУА-ийн хэвлэл. Улаанбаатар, 1987.

Гаадамба, Цэрэнсодном, 1978: *Гаадамба Ш, Цэрэнсодном Д.* Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Улсын хэвлэлийн газар. Улаанбаатар, 1978.

Гаадамба, Сампилдэндэв 1988: *Гаадамба Ш. Сампилдэндэв Х.* Монгол ардын аман зохиол. АБЯ-ны хэвлэл Улаанбаатар, 1988.

Мелетинский, 2005: *Мелетинский Е. М.* Герой волшебной сказки. Москва–Санкт-Петербург: “Традиция”, 2005.

Мордовина, Пеньков, 2009: *Мордовина Л. В, Пеньков Р.* Семантика семьи семейных отношений в мифе и сказке // *Аналитика культурологии*. 2(14). С. 88–89.

Цэрэнсодном, 2009: *Цэрэнсодном Д.* Монгол ардын үлгэр. Улаанбаатар: “Тод бичиг” хэвлэлийн газар, 2009.

ПРОЯВЛЕНИЕ СЕМЕЙНЫХ ОТНОШЕНИЙ В МОНГОЛЬСКИХ БЫТОВЫХ СКАЗКАХ

Б. ДАЙРИЙМАА

Институт языка и литературы Монгольской академии наук

Монгольские народные сказки, независимо от их жанровых особенностей, отражают различные социальные явления. Как правило для изображения общественной жизни используется прием аллегории. Скрытый смысл присутствует в сказках о животных, сатирических и бытовых. Однако в бытовых сказках идеи могут быть выражены и открыто, без использования иносказания. Одной из многочисленных тем народных сказок является тема семьи. В основе сюжетов подобных сказок всегда находятся моральные ценности, часто выраженные символически.

Ключевые слова: монгольский фольклор, отражение, социальные институты, стереотипы, символы, моральные ценности.

Об авторе: **Баасанжаргал Дайриймаа**. Научный сотрудник сектора фольклористи Института языка и литературы Монгольской академии наук (Улан-Батор, Монголия) (dairiimaab@mas.ac.mn).

MANIFESTATION OF FAMILY RELATIONS IN MONGOLIAN NON-FAIRY TALES

B. DAYRIIMAA

Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

Mongolian folk tales, regardless of their genre features, reflect various social phenomena. In some cases, they contain hidden meaning. This is mainly observed in animal tales and satirical non-fairy tales. In addition, in non-fairy tales it is also expressed both in the direct sense and in a hidden, symbolic form. One of the many themes reflected in folk tales is the theme of family. The plot in such tales is based on elements containing moral values. They are often expressed in fairy tales with symbolic and hidden meaning.

Key words: Mongolian folklore, reflection, social institution, stereotypes, symbols, moral values.

About the author: **Baasanjargal DAYRIIMAA**. Researcher at the Folklore Sector of the Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (dairiimaab@mas.ac.mn).